***Э.Халиунбаяр*** *- ХСИС-ийн докторант,*
*цагдаагийн дэд хурандаа*

# МОНГОЛ УЛС ДАХЬ ТЕРРОРИЗМЫН өнөөгийн НӨХЦӨЛ БАЙДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү нийтлэлээр дэлхийн нийтийг хамарсан аюул, терроризмын тухай ойлголт, Монгол Улс дахь террориз.мын нөхцөл байдал, терроризмын шинжтэй бүртгэгдсэн гэмт хэргүүд, бий болох шалтгаан нөхцөл, тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд цагйаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, алба хаагчдын аюулгүй байдал зэрэг асуудлыг авч үзлээ.*

***Түлхүүр*** *үг: Терроризмын өнөөгийн нөхцөл байдал, терроризмийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх.*

Терроризм нь нэг улс үндэстний хүрээнээс хальж, хүн төрөлхтний үнэт зүйлс болох ардчилал, хүний эрх, эрх чөлөө, иргэдийн амар тайван амьдралд халдаж буй хамгийн харгис үйлдэл болж дэлхий нийтийн болоод аливаа улс орны аюулгүй байдалд бодит аюул занал учруулж байна.

Терроризм нь олон төрлийн хэлбэрээр илэрч болох тул улс орнууд терроризмыг өөрийн нөхцөл байдалд үндэслэн, дараах байдлаар тодорхойлж хуульчилсан байдаг.

*Хүснэгпг 1. Терроризмын тухай тодорхойлолт*

| | |
|---|---|
| АНУ | Терроризм гэж улс төрийн болон нийгмийн зорилгодоо хүрэхийн тулд төр засагт шахалт үзүүлэх, энгийн иргэдийг айлган сүрдүүлэх аргаар бие хvh, тэдний эд хөрөнгийн эсрэг хууль бусаар хүч хэрэглэх, хүчирхийлэхийг хэлнэ. |
| ОХУ | Терроризм бол хувьсгалт болон экстремист агуулгатай хүчирхийлэл, хүмүүсийг алан хядах, хулгайлах, барьцаалах зэрэг гэмт үйлдэл мөн. |
| ИБУИНВУ | Улс төр, шашин, үзэл суртлын төлөө түүний дотор нийгмийг эсхүл тодорхой хэсгийг айдаст автуулахаар харгис хүчирхийлэл хэрэглэх нь терроризм юм. |
| ХНБГУ | Терроризм нь улс төрийн зорилгоор төр, засгийн байгууллагуудад шахалт үзүүлэх, иргэдийг айлган сүрдүүлэх, заналхийлэх аргаар хийж буй тэмцлийн хэлбэр.[1] |
| Монгол Улс | Терроризм гэдэг нь хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцлийг бүрдүүлэх ажиллагаа.[* 2] |

[1]2013 оны Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны хэлэлцүүлгээс
[2] Монгол Улсын эрүүгийн хуулийн 178' дугаар зүйлийн 178". 1 дэх заалт.

Терроризмтой тууштай тэмцэх чиглэлээр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 тоот тогтоолд[1] терроризмын үндсэн хөрс суурь нь гэмт үйлдлийн аргаар олсон хууль бус орлого, зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодис, галт зэвсэгийн хууль бус эргэлт, хүн худалдаалах гэмт хэрэг мөн гэж тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү тогтоолыг дэлхийн олон улс орны эрх бүхий байгууллагууд баримталж ажилладаг. Мөн Монгол Улс нь терроризмтэй тэмцэхэд чиглэсэн олон улсын 19 конвенц, протокол баримт бичгийн арвангуравт нэгдэн орсон байдаг.[1 2]

Монгол улсын хөрш зэргэлдээ БНХАУ, ОХУ, БНКазУ зэрэг улсуудад салан тусгаарлах хэт даврагч үзэл, шашин, үндэстэн хоорондын мөргөлдөөн үргэлжилж, террорист халдлагууд өсөн нэмэгдсээр байна.

Монгол Улсын хойд хөрш болох ОХУ-ын хувьд 1700 орчим иргэд "Исламын улс бүлэглэл" террорист байгууллагын гишүүн бөгөөд тэдгээр нь ихэвчлэн хойд Кавказын бүлэглэлийн гишүүд байдаг. 2013-2014 онд ОХУ-д нийт 434 халдлага үйлдэгдсэнээс 435 энгийн иргэд амь насаа алдаж, 938 хүн шархаджээ. ОХУ нь террорист аюул заналхийллийн глобал индексээр дэлхийн нийт 162 орноос 8-т жагсаж, терроризмын өндөр эрсдэлтэй улс орны тоонд багтаж байна.

Монгол Улстай хамгийн ойр орших Төв Азийн Ислам шашинт Улс болох Бүгд Найрамдах Казакстан Улсад 2010-2014 онд нийт 11 террорист халдлага гарч,10 гаруй хүн амь насаа алджээ. Тус улсаас Исламын улсыг зорьж, байлдааны ажиллагаанд оролцож буй 250 хүн бий гэсэн судалгаа гарсан байдаг ба БНКазУ нь террорист аюул заналхийллийн глобал индексээр 162 орноос 46-д бичигдсэн байна.[3]

Монгол Улсын урд хөрш болох БНХАУ-ын Шинжан, Уйгарын өөртөө засах орноос зүүн Туркестаны хөдөлгөөний гишүүн болох 300 орчим дайчид Исламын улс бүлэглэлийн талд тулалдаж байгаа гэсэн мэдээлэл байдаг.

Монгол Улс баруун талаараа Зүүн Туркестаны лалын байгууллагатай идэвхтэй ажилладаг ШУӨЗО-той 1000 гаруй км газраар хиллэдэг. Хятадын холбогдох албанаас “Зүүн Туркестаны Исламын хөдөлгөөн" бүлэглэл нь бие даасан зүүн Туркестаны улсыг байгуулж, Шариатын засаглалыг тогтоох туйлын зорилготой гэж үздэг. Хятад улсад 2010-2014 оны байдлаар нийт 21

[1] НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 тоот тогтоол, протокол.
[2] НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн Терроризмтой тэмцэх хорооны Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын тайлан. 2015.05 сар
[3] Global Terrorism Index Report 2015, Institute for Economics and Peace

террорист халдлага гарсны 12 халдлага нь 2013 онд үйлдэгдсэн. Эдгээр халдлагын нийт 106 хүн амь насаа алдаж, 141 хүн шархадсан тоон үзүүлэлт байна. БНХАУ нь террорист аюул заналхийллийн глобал индексээр 162 орноос 23-т жагссан байна.

Монгол Улс нь 2015 оны террорист аюул заналхийллийн глобал индексээр 162 орноос 124-т буюу эрсдэл багатай түвшинд жагсаж, хамгийн бага эрсдэл бүхий 38 орны тоонд багтжээ. Гэвч Монгол Улсад 2003 оноос хойш өнөөдрийг хүртлэх хугацаанд нийт 18 удаагийн террорист шинжтэй үйлдэл бүртгэгдсэн байдаг[1].

Монгол Улсын хувьд бас нэгэн анхаарал татаж буй асуудал нь БНТУ руу Монгол Улсаас хийж буй шууд нислэг бөгөөд энэхүү зам, сувгаар Ислам шашинт террорист этгээдүүд манай улсад нэвтрэх эрсдэл өндөртэй, ялангуяа нислэг үйлдэж буй Истанбул хот нь Исламын Улс руу шууд нэвтрэх гол суваг болоод байгааг анхаарах нь зүйтэй байна.

Аливаа терроризм үүсэх, террорист ажиллагаа, үйлдэл гарах үндсэн болон туслах хүчин зүйлс бий. Үндсэн хүчин зүйлд олон улсын болон бүс нутгийн хямралт байдлын нөлөө, тухайн улсын дотоод нөхцөл байдал, тэр дундаа үндэсний эв нэгдэл, үндэстэн, ястан, шашин хоорондын харилцаа багтдаг бол туслах хүчин зүйлд тухайн улсын терроризмоос урьдчилан сэргийлж буй байдал, тагнуул, цагдаа болон хууль сахиулах байгууллагын чадвар, терроризмын үзэл санаа нэвтрэн орж ирэх магадлал, террорист үйлдэл хийхэд шаардлагатай зэвсэг, хэрэгсэл олж авах боломжит нөхцөл зэрэг хамаардаг.

*Нийгэм, эдийн засаг, нам, улс төрийн тогтворгүй байдал:* Улс төр, нийгэм, эдийн засгийн салбарт үүсээд буй зарим тулгамдсан асуудал нь олон нийтийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж нийгэмд тогтворгүй байдал үүсгэж болзошгүй эрсдэлт хүчин зүйлсийг нэмэгдүүлж байна. Сүүлийн үед зарим нам, эвсэл улс төрийн хүрээнд үүсээд буй асуудлыг валютын ханшийн өсөлт, инфляци, төсвийн бодлого, гадаад өр, төмөр зам, “Тавантолгой” төсөл зэрэгтэй холбон УИХ, Засгийн газрын үйл ажиллагааг буруутгасан өнгө аястай мэдээллийг олон нийтэд хүргэж байна. Энэхүү үйлдлээ иргэний хөдөлгөөн, ТББ-уудаар дамжуулан олон нийтийн эсэргүүцлийн шинжтэй үйл ажиллагаа болгон өргөжүүлэхийг эрмэлзэж байна.

Эрүүгийн гэх зохион байгуулалттай гэмт этгээдүүд хууль зөрчих нь ердийн үзэгдэл болох, гэмт хэргийн гаралт өсөж, санаа зорилго нэг бүхий

[1] Эрүүгийн цагдаагийн газрын мэдээлэл, судалгаа

хүмүүс нэгдэн зохион байгуулалтад орж, төр засгийн эрх мэдэл, хяналттай өрсөлдөх хэмжээнд идэвхжин, өөрсдийн зөв гэж үзсэн үйлдлийг хүч түрэмгийлэн хэрэгжүүлэх, нийгмийн хэв журмыг зохион байгуулалттайгаар зөрчих хандлагатай болсон. Улс төрд өөрсдийн төлөөллөө хүчээр багтаан оруулахаар эрмэлзэж эхэлсэн.

Түүнчлэн. ядуурал их байгаатай холбоотойгоор иргэдийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болоод террорист үйл ажиллагаанд эд хөрөнгөөр ашиглах оролдлого гарч болох талтай. 2015 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 28% буюу 874,000 иргэн амьжиргааны төвшнөөс доогуур амьдралтай, 1.45% буюу 50,800 өнчин хүүхэд байна гэсэн судалгаа гарсан[1].

*Уул уурхай, тэсрэх бодисын эргэлт:* Монгол Улсад сүүлийн 10 орчим жил уул уурхайн бизнес эрчимтэй хөгжиж үүнтэй холбоотойгоор уул уурхайн зориулалт бүхий тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт нэмэгдсэн. Улсын хэмжээнд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил эрхлэх. тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрөлтэй 145 аж ахуй нэгж бүртгэлтэй, тэдгээр нь 23 нэр төрлийн тэсрэх материалыг голчлон ашигладаг. Дээрх аж ахуйн нэгжүүд 2014 оны байдлаар 17.3 мянган тонн тэсрэх бодис ОХУ болон БНХАУ-аас импортолж, 74.5 мянган тонн тэсрэх бодис үйлдвэрлэсэн бөгөөд тэдгээрийн нийт өртгийг тооцож үзвэл жилдээ 85 мянга орчим тонн тэсрэх бодис буюу 80-100 тэрбум төгрөг тэсрэх бодисын зах зээлд эргэлдэж байна. Улсын хэмжээнд нийслэл хот болон 21 аймгийн 94 газарт тэсрэх бодисын үйлдвэр. агуулах байршиж байна.

*Галт зэвсэг, сум хэрэгслийн хууль бус эргэлт:* Галт зэвсэг, сум хэрэгсэлд тавих хяналт сул, “Нарантуул ОУХТ”, “Хар хорин зах”-уудад хууль бусаар галт зэвсэг, сум худалдаалах үйл ажиллагаа явагдсаар байна. Монгол улсад 2015 оны байдлаар иргэн, хуулийн этгээдэд өмчлөгдөж байгаа 46,982 галт зэвсэг бүртгэгдсэнээс ангийн зориулалттай 44,306, харуул хамгаалалтын 1619, спорт сургалтын 566, үзмэр урлагийн 260, цуглуулгын зориулалттай 199 байна. Иргэдийн гар дээр байгаа зөвшөөрөлгүй, хууль бусаар хадгалагдаж байгаа галт зэвсгийн тоог тогтоох боломжгүй ч албан бус судалгаагаар 30 мянга орчим гэсэн дүнтэй байдаг[1] [2].

[1] Цахим эх сурвалж. www.1212.mn. Статистик мэдээллийн сан
[2] Цагдаагийн ерөнхий газрын галт зэвсгийн сан, судалгаа, статистик мэдээ.

Сумны хууль бус наймаагаар мэргэшиж зохион байгуулалтанд орсон 5-6 бүлэг буюу 50-60 орчим ченж нар байдаг, эдгээр бүлгүүд сум хэрэгслийг цэргийн ангиудаас, хууль бусаар улсын хилээр оруулж ирж буй иргэдээс худалдан авдаг. Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар байлдааны зориулалттай гар буу 66, байлдааны мэргэн буудагчийн буу 4, гар пулемёт 3, Клашниковын автомат 32 эрэн сурвалжлагдаж байна[1].

*Хэвлэл мэдээлэл, интернет цахим орчин:* Интернэтийн орчинд зураг, дүрс бичлэг, мэдээ материал болон санал сэтгэгдэл тавих зэргээр терроризмыг илт дэмжиж сурталчилсан шинжтэй үйлдэл гарсаар байна. Тухайлбал: Иргэн "Т" нь сайтад "Tileshka Abdurahman” нэрээр өөрийн профайл үүсгэж, Хойд Кавказ, Ирак, Палестины террорист байгууллагын зарим удирдагч, гишүүд, зэвсэгт дайчдын зургийг байрлуулан, “Израйль Америк руу дайръя” гэх зэргээр өдөөн хатгасан сэтгэгдэл бичиж улмаар сайтын “Jihad”, “Allah akbar”, “Kazak” зэрэг бүлгүүдэд гишүүнээр элсжээ[1] [2].

Хүчирхийллийн аргаар алан хядах ажиллагаа явуулахын зэрэгцээ банк, санхүүгийн системээр дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, техник-технологийн ололтыг ашиглан шинэ төрлийн террорист үйлдэл, түүний дотор цахим орчинд халдах, кибер-терроризм үйлдэгдэх бодит аюул нүүрлээд байна.

Монгол Улсын хэмжээнд интернетийн хяналт хангалтгүй бөгөөд терроризмын үзэл санаа, шинэ гишүүн элсүүлэх үйл ажиллагаа явагдахад түүнийг тогтоож, таслан зогсоох боломжгүй гэсэн үг.

Био-террор: Монгол Улс нь 2003 оноос хойш олон улсын энхийг сахиулах ажиллагаанд өөрийн цэргийн багийг оролцуулж эхэлсэн ба үүгээрээ террорист байгууллагуудын саарал жагсаалтанд багтсан. Тухайн цаг үед буюу 2008 онд Монгол Улсад байрлах гадаад улсын элчин сайдын яам болон Олон улсын байгууллагад удаа дараалан шуудан захидал харилцаагаар дамжуулан боомын бактер өвчин тараахыг завдсан үйлдлүүд гарч байсан.

Террорист халдлага гарч болзошгүй барилга байгууламж, өртөж болзошгүй объектуудын харуул хамгаалалт сул, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хангалт хүрэлцээгүй байна. Тухайлбал: хяналтын камерын иж бүрэн систем байхгүй, захидал харилцаа илгээмж хүлээн авах тусгай өрөө тасалгаагүй гэх мэт.

[1] Цагдаагийн ерөнхий газрын эрэн сурвалжлах “АСАР” сангийн мэдээлэл. 2015.
[2] Эрүүгийн Цагдаагийн газрын ЗБГХТХ-ийн судалгаа, статистик мэдээ.

*<u>Шашны урсгал, чиглэл нөлөөлөл:</u>* Ойрх дорнодын исламын шашинтай улс орнуудад шашны чиглэлээр суралцахаар явж байгаа иргэдийн урсгал улам бүр нэмэгдэж. Монгол иргэдэд тавих хяналт байхгүйгээс шашны хэт даврах үзэл нэвтрэх нөхцөл байдал үүсэж болзошгүй байна. “Монголын мусульман нийгэмлэгүүдийн холбоо”, “Ислам шашинтны муфтиат холбоо” болон БНТурк Улсын Элчин Сайдын яамны шугамаар 2005 оноос 2014 онд 727 монгол хүүхдүүдийг шашны байгууллагын чиглэлээр санхүүжүүлэн гадаад улс орнуудад суралцуулсан байдаг. Тэдний 490 нь эрэгтэй, 237 нь эмэгтэй байна.[1]

*Хүснэгтп 3. Монгол Улсад хуулийн этгээдийн бүртгэлтэй 654 шашны байгууллага (2016 он)*




Христийн шашны протестант урсгалд хамаарагдах Эх Бурхан, 7 дахь өдрийн Адвентист, Мормон, Еховагийн гэрчүүд, Мүүн зэрэг урсгал нь Библийг гажуудуулж буруу зан үйл явуулдаг гэсэн тодотголыг олон улсын зүгээс өгч, зарим улс орон шүтэхийг хориглодог боловч эдгээр нь бүгд манай улсад өөр өөрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсаар байна.

Сүүлийн үед "Монголын Мусульман нийгэмлэгүүдийн холбоо” болон “Муслим шашинтны муфтиат холбоо"-ны хооронд гаднаас санхүүгийн эх үүсвэр олж авахын төлөө өрсөлдөөн бий болсон нь олон улсын террорист байгууллагын анхаарлыг татах, энэ зам сувгийг ашиглан Монгол Улсад орж ирэх боломжийг бодитойгоор бий болгосон.

Ислам шашны Сулейменжи урсгалын “Таблиги Жамаат” бүлэглэл нь терроризмийг хүчтэй дэмжигч шашны хөдөлгөөн юм. Тажикстанд 2006 онд, ОХУ-д 2008 онд, Казакстанд 2009 онд тус бүлэглэлийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Тус “Таблиги Жамаат” хөдөлгөөн нь хэт даврагч үзэл баримтлалтай, буруу, гаж дэг жаягтай, хамгийн хатуу. харгис хэрцгий гэдгээрээ дэлхий нийтэд танигдсан.

Тус хөдөлгөөнд нэгдэн орсон, элссэн хүмүүсийн ихэнх нь Пакистан улсын Райван хотод шашны сургуулиудад очиж суралцахыг эрмэлздэг аж. Эдгээр шашны сургуулиуд төрийн ямар ч хяналтгүй, ямар хүнийг юуны чиглэлээр бэлтгэж байгааг ихэнх улс орнууд сайн мэддэггүй гэж судлаачид

[1] Эрүүгийн цагдаагийн газрын 2014 оны мэдээлэл, судалгаа

үздэг гэнэ[1]. Тухайн шүтэгчийнхээ оюун санааг удирддаг. хар тамхи хэрэглэсэн мэт мансуурлын байдалтай болгодог бөгөөд сүүлийн жилүүдэд амиа золиослогчдыг бэлддэг болсон нь ил болоод байгаа юм. Монгол улсад 2005 оноос хойш Баян-Өлгий, Ховд аймагт "Таблиги Жамаат" бүлэглэлийн биет төлөөлөгч болох 48 хүн, 17 удаагийн үйлдлээр ирж, тодорхой тооны Монгол иргэдийг гадаад улсад шашны суртал ухуулга, сургалтанд хамруулсан судалгаа байдаг[1 2].

Судлаач миний хувьд Монгол Улсад террорист халдлага үүсэх олон талын нөхцөл байдал бий болоод байгаа талаар тоо баримт, жишээнд тулгуурлан харуулахыг хичээлээ. Учир нь дэлхий нийтийг хамарсан аюултай үзэгдэл болох терроризмтой тэмцэхэд тагнуул болон цагдаагийн байгууллагууд хамтран ажиллаж, терроризмын гэмт үйлдлийг үйлдэгдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх нөхцөл, боломжийг судалж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3. дахь хэсэгт "Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмоос сэргийлэх талаар мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулж ажиллуулна гэж заасан.

Мөн, Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3- "Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед зөвхөн дэг журам сахиулах[3] эрх хэмжээг хэрэгжүүлэх"-ээр тусгасан байдаг.

Дээрх хуулиудын холбогдох заалтуудаас харахад, терроризмтой тэмцэх, түүнээс сэргийлэх ажилд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, ажлын нарийвчилсан чиглэл тодорхойгүй байгаа тул цагдаагийн байгууллага нь нийтлэг ажил үүргийн хүрээнд оролцохоос хэтрэхгүй байгаа юм. Энэ нь Цагдаагийн байгууллагын Эрүүгийн албаны зүгээс гүйцэтгэх ажлын шугамаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үндэсний эрх зүйн орчин бүрдээгүй байгааг харуулж байна.

[1] http://mongolcomment.mn/index.php?newsid=8882 сэтгүүлч Г.Ялгууны нийтлэл. Өдрийн сонин.

[2] ЭЦГ-ын ҮДЗБГХТХ-ийн судалгаа, мэдээлэл. 2015.

2013.07.05-ны өдөр батлагдсан. "Цагдаагийн албаны тухай хууль".

Мөн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлд Тагнуулын байгууллагын зүгээс $178^{3}$ /Терроризм/, $178^{2}$ /Терроризмыг санхүүжүүлэх/, $178^{3}$/Терроризмыг сурталчлах/, 224.2 /Олон улсын нислэгийн журам зөрчих/ зэрэг гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар заасан байдаг. Харин цагдаагийн байгууллагын зүгээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27.1, 27.3. дахь хэсэгт заасан тагнуул, авлигатай тэмцэх газрын харьяалалаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар заасан нь тагнуулын байгууллага болон авилгатай тэмцэх газрын харьяаллын хэрэгт мөрдөн байцаалт явуулах, шалгах, түүнд дэмжлэг үзүүлэх байдлаар оролцох эрх, үүрэг байхгүй байгааг илэрхийлж байна.

Гэвч өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллага нь терроризмын шинжийг агуулсан бүхий л төрлийн хэргийн дуудлага мэдээлэл авч холбогдох ажиллагааг хийх, хэргийн газрын үзлэг хийх, хойшлуулшгүй ажиллагааг явуулах болон зарим тохиолдолд эрх бүхий хуулийн байгууллагуудтай хамтарсан шалгалтын ажиллагааг гүйцэтгэж байгаа юм.

Тагнуулын байгууллага нь төрийн ордон, яам, агентлагийн байр болон төрийн тусгай хамгаалалттай бүс нутагт терроризмын шинжийг агуулсан гэмт үйлдлийг, харин цагдаагийн байгууллага нь эдгээрээс бусад газар нутаг, орон зай, бүсэд үйлдэгдсэн харьяаллын болон харьяаллын бус бүх төрлийн гэмт хэргийн дуудлага, мэдээллийг хүлээн авч, хэргийн газрын үзлэг хийж, хойшлуулшгүй ажиллагаа явуулсны дараа прокурорын байгууллагад хандан хэргийн харьяаллыг тогтоолгож байгаа нь хэргийг шалгах эрх бүхий байгууллагад цаг хугацаа алдаж мэдээлэл хүргэгддэгээс хэрэг шалгах ажиллагаанд сөргөөр нөлөөлж байж болзошгүй юм.

Терроризмын хэлбэр, шинжийг агуулсан байж болох цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн, шалгагдсан үйлдэл, гэмт хэргийн дуудлага мэдээллээс дурьдвал:

- Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Сүхбаатарын талбай, МАН-ын төв байр болон түүний орчинд 2008 оны 7 дугаар сарын 1-нд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсч 5 хүний амь нас хохирсон хэрэг,
- Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар мөн АНУ-ын элчин сайдын яаманд нэр хаяг тодорхойгүй, боом өвчний вирус шингээсэн захидал илэрсэн хэрэг
- Архангай, Дорнод аймгуудын цэвэр усны нөөцийн байгууламжинд химийн бодис асгаж хордуулахаар санаархсан үйлдэл.

> Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймагт уул уурхайн зориулалт бүхий тэсрэх бодис алдагсан, дэлбэрсэн зэрэг хэрэгт цагдаагийн байгууллагаас хэргийн газрын үзлэгийг бие даан болон холбогдох байгууллагатай хамтран хойшлуулшгүй ажиллагааг явуулсан байдаг юм.

Иймд терроризмын төрөл, шинжийг агуулсан үйлдэл, гэмт хэрэг үйлдэгдсэн, дуудлага мэдээлэл ирсэн тохиолдолд цагдаагийн байгууллагаас хэргийн газрын үзлэгийг явуулах, хэргийн газар дээр ажиллах мэргэшсэн, чадварлаг бүрэлдэхүүн болох алба хаагчдыг урьдчилан бэлтгэсэн байх шаардлага тулгараад байна.

Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд тагнуулын байгууллага нь өөрсдөөс илрүүлсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 /Хүн худалдаалах/, 166[1] /Мөнгө угаах/, 175 /Эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх/ зэрэг зүйлд заагдсан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах эрхийг давхардуулан олгосон байдаг.

Үүнээс харахад, цагдаагийн байгууллагад ч мөн адил нийгэмд учрах хор аюулын хэмжээ өндөртэй, тодорхой төрлийн хэргүүдэд мөрдөн байцаалт явуулах эрхийг давхардуулан олгох эрх зүйн зохицуулалт боловсруулж болох юм.

Тухайн нөхцөл байдалд цагдаагийн байгууллагаас терроризмын шинжийг агуулсан хэргийг үйлдлийн аргаар нь дараах байдлаар төрөлжүүлэн ангилж болох юм. Эдгээр нь: Галт зэвсэг хэрэглэсэн, тэсрэх бодис ашигласан, химийн бодис ашигласан, хүн барьцаалсан шинжтэй тохиолдол гэх мэт.

Мөн хэргийн газрын үзлэгийг явуулах хүрээ хязгаараар нь газар зүйн онцлог, барилга, байгууламж, галт тэрэг, авто машин болон бусад обьект, цаг агаарын нөхцөл зэргийг уялдуулан чанартай хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжил, арга зүйн сургалтын материал, гарын авлага зэргийг ХСИС-ийн холбогдох тэнхимтэй хамтран боловсруулж, түүнийг алба хаагчдаар судлуулж, ажил албанд нь мөрдлөг болгон хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй юм.

Хэрэв цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үндэсний эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд:

Үйлдлийн аргаар төрөлжүүлсэн терроризмын шинжийг агуулсан хэргийн газрын үзлэгийг явуулах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах алба хаагчид аюулгүй байдлыг ханган ажиллах талаар зөвлөмж боловсруулан мөрдүүлэх.

Тухайн төрлийн хэргүүдийг шалгах, ул мөр бэхжүүлэхэд шаардлагатай олон улсын хэмжээнд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.

Терроризмын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн газар, хэлтсийн алба хаагчдыг тусгай программ хангамж, техник хэрэгсэлээр хангах, холбогдох сургалтанд үе шаттайгаар хамруулах, тогтвор сууршилтай ажиллуулах нөхцөл боломжоор хангах нь чухал юм.

Дээр дурьдагдсан ажил, үүргүүдийн талаарх эрх зүйн баримт бичгийг боловсруулж Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны заавар журамд нарийвчлан тусгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Терроризмын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд оролцох эрх, үүргийг Цагдаагийн байгууллага нь өөртөө дангаар авах бус нийгэмд аюултай хор уршгийг тооцсоны үндсэн дээр олон улсын жишигт нийцүүлсэн энэ төрлийн гэмт хэрэгтэй тагнуул болон бусад хууль хүчний байгууллагуудтай хамтран тэмцэх ажиллагааг явуулах нь зүйтэй.

Ийнхүү хамтын ажиллагааны дүнд тус гэмт халдлага, үйлдлийг захиалсан. гүйцэтгэсэн. зохион байгуулсан сэжигтэй этгээд гэмт бүлэглэл зэрэг нь бүрэн тогтоогдсон тохиолдолд тухайн хэргийн мөрдөн шалгах ажиллагааг Тагнуулын байгууллага нь цааш үргэлжлүүлэн явуулахаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь илүү оновчтой, үр дүнтэй болохыг судлаач миний хувьд дүгнэж байна.

Дэлхийн бусад улс орнуудын хувьд цагдаагийн байгууллагын зүгээс терроризмтэй тэмцэх чиглэлээр хууль сахиулах эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн орчин тодорхой байдаг. Энэ нь тухайн төрлийн гэмт хэргийг газар авахуулахгүйгээр таслан зогсоох гол үндэс суурь болж байгаа тул үүнийг бид нарийвчлан судалж, амьдралд хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Монгол Улсын хувьд терроризмтой тэмцэх нь дан ганц тагнуулын байгууллагын ажил бус цагдаагийн байгууллагын зүгээс ч энэ чиглэлээр хамтран ажиллах эрх зүйн орчин бий болгох нь нэн тулгамдсан хүлээлт үүсгээд байгаа ажил юм.

Мөн терроризмтой тэмцэхэд цагдаагийн байгууллага нь дэмжлэг үзүүлэн ажиллах чадвартай, мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэх, холбогдох хууль, хүчний байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах эрх зүйн баримт бичиг боловсруулах шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үндэсний эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд үйлдлийн аргаар төрөлжүүлсэн терроризмын шинжийг агуулсан хэргийн газрын үзлэгийг

хийж гүйцэтгэх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах алба хаагчдын аюулгүй байдлыг ханган ажиллах талаар зөвлөмж боловсруулан мөрдүүлэх. тухайн төрлийн хэрэг шалгах ажиллагаанд шаардлагатай олон улсын хэмжээнд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг саналыг дэвшүүлж байна.

***Н.Амарсанаа** -Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

# ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТАНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

***Хураангуй.** Энэхүү сэдвээр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй гэмт хэргээс уръдчилан сэргийлэх ажлын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байгаа талаар таамаглал дэвшүүлэн гаргахыг зорилоо.*

***Түлхүүр үг.** Гэмт хэргээс уръдчилан сэргийлэх, хууль эрх зүй, ажлын дүн мэдээний үзүүлэлт, төрөөс баримтлах бодлого.*

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь эдийн засаг, соёл, ёс суртахуун, тухайн нийгмийн түүхэн тодорхой нөхцөл, хүмүүсийн аж амьдралын түвшин, хуулийн хэрэгжилт. эрх зүйн соёл, улс төрийн удирдлагын чадвар зэрэг олон талын хамааралтай байдаг.

Гэмт хэрэгтэн өөрийн оршин суугаа гудамж, хорооны нутаг дэвсгэртээ гэмт хэрэг үйлддэг, өөрөөр хэлбэл ахуйн хүрээнд үйлдэгддэг байсан бол одоо цагт илүү зохион байгуулалттай, бүлэглэж, нууц далд аргаар өргөн хүрээнд гарах боллоо.

Гэмт хэрэг үйлдэж буй арга, ашиглаж байгаа техник хэрэгсэл орчин үеийн хөгжил, глобалчлалыг дагаад улам боловсронгуй болж өөрчлөгдөж байгаагийн эсрэг цагдаагийн байгууллагын алба хаагч бид ажилдаа мэргэшсэн байхаас гадна цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах чадвартай байх хэрэгцээ тулгарч байна.

Хууль сахиулах байгууллагаас гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэний дараа түүнийг илрүүлэхээр ажиллахад ихээхэн цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө зарцуулагдахаас гадна нийгэм, эдийн засагт тэр хэмжээгээр хохирол учирч, хууль тогтоомж зөрчигддөг.

Иймд гэмт хэргийг гарсны дараа биш гарахаас өмнө урьдчилан сэргийлэх нь нийгмээрээ амар тайван, аюулгүй ажиллаж, амьдрах нөхцөл боломжоор хангагдах зүй тогтолтой юм.